



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 9/583

Мөрөн сум

Залуучуудын хөгжлийн төвийн бизнес
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2023 оны 378 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит XVII хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Залуучуудын нийгмийн хөгжилд оруулах хувь нэмэр, идэвх оролцоог нэмэгдүүлэх, тэдний хөгжил, боловсрол, соёл урлаг, спорт, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэн Залуучуудын хөгжлийн төвийн бизнес төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд туссан ажлуудыг хэрэгжүүлэхэд санал, санаачилга гаргаж хамтран ажиллахыг аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийн газар (Л.Батцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Залуучуудын хөгжлийн төвийн өдөр тутмын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллахыг “Хөвсгөл аймгийн Залуучуудын хөгжлийн төв” (ОНӨААТҮГ)-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ